төрийн худалдан авах ажиллагааны tender.gov.mn системд тавьж тендерийг 100 хувь цахимаар зарласан. Тендерийн үнэлгээ дуусмагц тендерт шалгарсан 941 оролцогчийн тендерийн баримт бичгийг бусад оролцогчдод ил болгож, бараа, ажил, үйлчилгээ нийлүүлэгч 186 аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээг мөн цахим системд нийтэлсэн. Ингэснээр аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа захиалагч байгууллагуудын тендер шалгаруулалтын үйл явцын болон гэрээний мэдээллийг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем tender.gov.mn болон Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын Khvsgol.gov.mn, Орон нутгийн өмчийн газрын umch.khs.gov.mn цахим хуудсанд хуульд заасан хугацаанд нийтэлж, худалдан авах ажиллагааны бүх шатны мэдээллийг олон нийтэд ил тод нээлттэй "шилэн" болгосон.

2022 онд тендер шалгаруулалттай холбоотой дараах гомдолыг шийдвэрлэж гомдлын бүртгэлд бүртгэсэн. Үүнд:

1. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжих "Төрийн албан хаагчдын ажиллах нөхцлийг сайжруулах, тоног төхөөрөмжөөр хангах" төсөл арга хэмжээний тендерийн үнэлгээ хууль нийцээгүй тухай гомдлыг "Монтех дистрибьюшнъ" ХХК-аас Сангийн яаманд гаргасан бөгөөд сангийн яамны 2022 оны 03/3105 дугаар албан бичгээр захиалагчийн шийдвэр үндэслэлгүй гэж дүгнэсэн шийдвэрийг хэрэгжүүлж тендерийн үнэлгээг дахин хийсэн.
2. Япон улсын Засгийн газрын "Өвсний үндэс хөтөлбөр"-өөс санхүүжих 150 хүүхдийн дотуур байр засварлах ажил /Хөвсгөл, Цэцэрлэг сум/ төсөл арга хэмжээний талаар оролцогч "Голден прогресс" ХХК сангийн яаманд гомдол гаргасан бөгөөд сангийн сайдын 2022 оны 03/4617 дугаар албан бичгээр "Ихрийн бууц" ХХК-ийг шалгаруулсан тендерийн үнэлгээ үндэслэлгүй байх тул тендерийн үнэлгээг дахин хийх чиглэл өгсний дагуу тендерийн үнэлгээг хүчингүй болгож, тендерийг дахин зарласан.
3. Жижиг дунд усалгааны систем /Хөвсгөл, Галт, Бүрэнтогтох, Тлосонцэнгэл, Рашаант, Эрдэнэбуулган, Түнэл, Жаргалант сум/ төсөл арга хэмжээний тендерийн үнэлгээ хууль зөрчсөн байгна гэх гомдлыг "Колортийм" ХХК-аас сангийн яаманд гаргасан. Сангийн яамны 2022 оны 03/4971 дүгээр албан бичгээр ирүүлсэн дүгнэлтэд гомдлыг хянаад "Колортийм" ХХК-ийн тендерийн баримт бичгийн танилцуулга хэсэгт барааны техникийн тодорхойлолтын зарим орхигдсон заалтыг оруулсан байх тул LGP20-H загварын усны насосны бороожуулагч толгой, тулгуур хөл, түгээх усны хоолой нь техникийн тодорхойлолтын дээр дурьдсан үзүүлэлтэд нийцэх эсэхийг дахин нягталж үзэх нь зүйтэй гэсний дагуу тендерийн үнэлгээг дахин хийж "Колортийм" ХХК-ийг шалгаруулсан.
4. Аймгийн авто замыг хөгжүүлэх төлөвлөгөөг хэрэгжүүлэх /Мөрөн sumaas Хилэнтийн гүүрний чиглэлд авто зам барих/ажлын гүйцэтгэгчийг сонгох тендерт оролцсон "Хөвсгөл зам" ХХК тендерийн үнэлгээг үл зөвшөөрөх талаар сангийн яаманд гомдол гаргасан. Сангийн яамны 2022 оны 03/6516 дугаар албан бичигт "Хөвсгөл зам" ХХК-ийн санал болгосон машин механизм нь Голомт банкны нэр дээр бүртгэгдсэн бөгөөд Голомт банктай 2022 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр байгуулсан БГ491505357-1 дугаартай гэрээний 2.3-т "Барьцааны зүйлийг барьцаалуулагчийн эзэмшилд байлгах ..." гэж заасан байх тул машин механизм эзэмшигчийн талаар холбогдох байгууллагаас лавлах шаардлагатай байна гээд үнэлгээний хорооны шийдвэрийг хүчингүй болгосон. Иймд тендерийн үнэлгээг захиалагч дахин хийж Хөвсгөл зам ХХК-ийг шалгаруулсан.
5. Ковш худалдан авах /Тосонцэнгэл сум/ төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтад оролцсон "Монтех дистрибьюшнъ" ХХК тендерийн үнэлгээг үл зөвшөөрч сангийн яаманд гомдол гаргасан. Сангийн яамны 2022 оны 03/6878 дугаар албан бичигт "Альянс трейд"

ХХК-ийг шалгаруулсан үнэлгээний хорооны шийдвэр үндэслэлгүй гэж үзсэн. Сангийн яам “Монтех дистрибьюшн” ХХК-ийн гомдол үндэслэлтэй байгаа тул тендерийн үнэлгээг хүчингүй болгосон. Тендерийн үнэлгээг дахин хийж “Монтех дистрибьюшн” ХХК-ийг шалгаруулсан.

6. Орон нутгийн хөгжлийг дэмжих Шинэ хөдөө төслийн 14 дүгээр багцад оролцсон “Зора” ХХК нь татварын өртэй гэж татгалзсан захиалагчийн шийдвэрийг үл зөвшөөрч сангийн яаманд гомдол гаргасан. Сангийн яамны 03/7164 дүгээр албан бичигт захиалагчийн шийдвэр үндэслэлтэй гэж үнэлсэн.

Төсвийн шууд захирагч, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмч давамгайлсан аж ахуйн нэгжүүд нийт 168 байгууллагын худалдан авах ажиллагааны тайланг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.4 дэх хэсэг, Сангийн сангийн 2021 оны 102 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-д заасан хугацаанд хүлээн авч, тайланг хянаж нэгтгэсэн. 2022 онд аймгийн төсвийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа 168 байгууллагад худалдан авсан 64,2 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 1845 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны тайланг хууль, Сангийн сайдад журманд заасан хугацаа буюу 2023 оны 1 дүгээр сарын 15-ны өдрөөс өмнө хүргүүлэхээр бэлтгэж байна.

Тус газраас зохион байгуулсан тендер шалгаруулалтын 206 үнэлгээний хороонд ажилласан үнэлгээний хорооны гишүүд(төрийн албан хаагч-285, иргэн-183), бараа, ажил, үйлчилгээг нийлүүлэх гүйцэтгэгчийн гэрээг баталгаажуулах албан хаагч (давхардсан тоогоор төрийн албан хаагч 58) нийт 526 хүний Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдүүлэгийг Авлигатай тэмцэх газрын цахим системд нийтэлсэн.

Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа захиалагч байгууллагуудаас зарласан тендер шалгаруулалт болон бараа, ажил, үйлчилгээ нийлүүлэх гэрээний хэрэгжилттэй холбоотой зөрчил дутагдал илрээгүй тул хяналт шалгалт хийлгүүлэх хүсэлтийг ажлын 10 хоногийн дотор Худалдан авах ажиллагааны улсын байцаагчид хүргүүлэх шаардлага үүсээгүй байна.

Авилаа ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай батламж гэрээг 2022 оны 01 сарын 15-ны өдөр тус албаны 8 албан хаагчтай байгуулж, батламж гэрээг дүгнэсэн.

Өөрийн байгууллагын www.umch.kh.gov.mn, www.tender.khs.gov.mn цахим системийн мэдээллийг тогтмол шинэчлэн ажилласны үр дүнд 2022 онд тус цахим хуудсан иргэн хандаж мэдээлэл авсан.

Хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн чанар, үр дүнг аймаг, сумдын удирдлага, иргэдээр үнэлүүлэх цогц систем www.tender.khs.gov.mn цахим хуудсыг “Идеадевелопмент” ХХК-ээр хийлгэн, хөгжүүлэлтийг хэрэгжүүлж байгаа бөгөөд энэ хүү системийг бүрэн ажиллуулснаар улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжиж байгаа төсөл арга хэмжээний мэдээллийг олон нийт нээлттэй үзэж, танилцах, сэтгэгдэл үлдээх, аймаг сумдын удирдлага, захиалагч, гүйцэтгэгч төслийг удирдах, үнэлгээ, үүрэг даалгавар өгөх, гүйцэтгэлийг хянах бүрэн боломж бүрдэж байна.

Байгууллагын www.umch.kh.gov.mn сайтыг төрийн худалдан авах ажиллагааны tender.khs.gov.mn цахим системтэй холбож тендерийн урилга, үр дүн, гэрээ, гэрээний хэрэгжилтийн мэдээлэл зэргийг шууд нийтлэгдэг болгосноор албан хаагчдын ачааллыг бууруулж, мэдээлийн ил тод байдлыг хангасан үр дүнтэй арга хэмжээ болсон.

Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан "Барилга байгууламжийн угсралт, засварын ажлын гүйцэтгэлд захиалагчийн болон хөндлөнгийн хяналт тавих тогтолцоог боловсронгуй болгож барилга байгууламжийн ажлын чанарыг сайжруулах зорилт"-ын хүрээнд аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Захиалагчийн хяналтын төв, Барилгын хөгжлийн төв төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, Сэлэнгэ аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар -тай хамтран 2022 оны 03 сарын 02-05-ны өдөр "аймгуудын барилгын салбарын инженер техникийн ажилтнуудыг чадавхижуулах сургалт", 2022 оны 03 сарын 24-25-ны өдөр "Хөвсгөл аймгийн барилгачдын зөвлөлдөх уулзалт"-ыг тус тус зохион байгуулж дээрх 2 уулзалт, зөвлөгөөний үйл ажиллагааны бүх бичлэг болон хөрөнгө оруулалтаар хэрэгжих бүх төсөл арга хэмжээний мэдээллийг Хөвсгөл ард түмний телевиз, Мөрөн телевиз, Хөвсгөлийн өнгө сайтаар олон нийтэд нээлттэй мэдээлсэн.

Улс, орон төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн мэдээллийг улирал бүр аймгийн орон нутгийн Хөвсгөл ард түмний телевиз, Мөрөн телевизэд хүргүүлэн тухай бүр мэдээлж байна.

Тендерийн урилга, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг "Өглөөний сонин"-д нийтэлж, 2022 оны жилийн эцсийн байдлаар тус сонинд 4,100,000 (Дөрвөн нэг зуун мянган) төгрөгийг гэрээний төлбөрт төлсөн.


Монгол Улсын Их сургуулийн харьяа худалдан авах ажиллагааны сургалт мэдээллийн төвийн багш Н.Жавхлан, н.Ууганбаяр, Төрийн худалдан авах ажиллагааны газрын мэргэжилтэн Б.Чинбат нартай хамтран 2022 оны 2 дугаар сарын 26-ны өдрөөс 2022 оны 3 дугаар сарын 02-ны өдөр 255, Худалдан авах ажиллагааны сургалтын төвийн багш Н.Цолмон, Төрийн худалдан авах ажиллагааны газрын мэргэжилтэн Д.Одбаатар нартай хамтран "Тогтвортой амьжиргаа-3" төслийн 4.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 50, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар сургалт хийх тендерийг зарлахад Монгол Улсын Их сургуулийн харьяа худалдан авах ажиллагааны сургалт мэдээллийн төв ТББ оролцон шалгарч 2022 оны 9 сарын 15-20-ны өдөр 50, нийт 355 иргэнд А-3 сертификатын сургалт зохион байгуулсан бөгөөд дээрх сургалтуудыг зохион байгуулснаар төрийн байгууллага, орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн ажилтнуудыг чадавхижуулж, 241 иргэнд А-3 сертификат олгосон. Үүний үр дүнд захиалагч байгууллагуудын үнэлгээний хороонд ажиллах шаардлагатай хүний нөөц хангагдсан болно.

Тус газрын Худалдан авах ажиллагааны алба нь 2022 онд газрын даргын албан бичиг 679, газрын даргын тушаал 5, аймгийн Засаг даргын захирамж 9, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын тушаал 376, аймгийн Засаг даргын болон Тамгын газрын даргын албан бичиг 443, нийт 1512 нэгж баримт бичгийг бичиг хэргийн стандартын дагуу төлөвлөж иргэн, аж ахуйн нэгж байгууллагад хүргүүлсэн. Боловсруулсан баримт бичгийг мэргэжилтэн бүрээр харуулбал: 1. Албаны дарга Б.Болд: Засаг даргын захирамж-9, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын тушаал-266, аймгийн Засаг даргын албан бичиг-52, аймгийн Засаг даргын Тамгын газрын албан бичиг-72, Орон нутгийн өмчийн газрын албан бичиг-290, газрын даргын тушаал-5, хөтөлбөр, төлөвлөгөө-5 нийт 699 нэгж баримт бичиг боловсруулсан.

2. Х.Мөнх-Эрдэнэ: аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын албан бичиг-64, захиалгат-2, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын тушаал-45, Газрын даргын албан бичиг-88, нийт 199 нэгж баримт бичиг боловсруулсан.
3. Д.Төмөр: аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын албан бичиг-63, захиалагат тендерийн мэдэгдэл-80, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын тушаал-22, Газрын даргын албан бичиг-98, нийт 263 нэгж баримт бичиг боловсруулсан.
4. Д.Даваасамбуу: аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын албан бичиг-139, захиалгат тендерийн мэдэгдэл-8, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын тушаал-29, Газрын даргын албан бичиг-129, нийт 305 нэгж баримт бичиг боловсруулсан.
5. М.Даваацэрэн: аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын албан бичиг-84, захиалгат тендерийн мэдэгдэл-5, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын тушаал-24, Газрын даргын албан бичиг-78, нийт 191 нэгж баримт бичиг боловсруулсан. Б.Лхагвадорж: Газрын даргын албан бичиг-6, нийт 6 баримт бичиг боловсруулсан.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг 2021 онд хангалтгүй зохион байгуулсан сум байгууллагын удирдлагад арга хэмжээ авах саналыг Орон нутгийн өмчийн газрын 2022 оны 1/384 дүгээр албан бичгээр аймгийн Засаг даргад хүргүүлсэн. 2021 онд худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийг хангалтгүй хэрэгжүүлсэн 23 сумын Засаг даргад арга хэмжээ авах шийдвэрийг аймгийн Засаг даргын 2022 оны 1/1139-1/1162 дугаартай 24 албан бичгээр, мөн хууль тогтоомжийг хангалтгүй хэрэгжүүлсэн орон нутгийн өмчит 13 аж ахуйн нэгжийн удирдлагад арга хэмжээ авах шийдвэрийг аймгийн Засаг даргын 1/1163-1/1174 дүгээртэй 13 албан бичгийг бичгээр тус тус хүргүүлсэн.

Газрын дарга, Худалдан авах ажиллагааны албаны дарга, ахлах мэргэжилтэн, өмчийн ахлах мэргэжилтэн гэсэн 4 албан хаагчийн 2021 оны хөрөнгө орлогын мэдүүлгийг 2022 оны 2 дугаар сарын 10-ны өдөр цахимаар үнэн зөв тайлагнасан.



ХӨВСГӨЛ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ӨМЧИЙН МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2022-12-21

Орон нутгийн өмчийн газрын дарга болон өмчийн харилцаа хариуцсан З мэргэжилтэн Төрийн болон орон нутгийн өмичийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, журамд нийцүүлэн орон нутгийн өмчийн бүртгэл, тооллого, ашиглалт, хадгалалт хамгаалалтад хяналт тавьж, өмчийн удирдлагыг хэрэгжүүлж ажилласан бөгөөд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Орон нутгийн өмчийн удирдлагыг хууль тогтоомжид нийцүүлэн хэрэгжүүлэх, бүртгэл, ашиглалтад хяналт тавих чиг үүргийн хүрээнд.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх ас

уудлын хүрээний төсөвт байгууллага -190, төсөвт үйлдвэрийн газар-5, орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой компани-15, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар-9, сан, төсөл-86, улсын бүртгэлийн гэрчилгээтэй 219 орон нутгийн өмчит хуулийн этгээд, нийт 305 нэгж байгууллагын эзэмшилд байх орон нутгийн өмчийн хөрөнгийн бүртгэл, тооллого, хяналт, удирдлагыг хэрэгжүүлж, орон нутгийн өмчид хөрөнгө бүртгэх, худалдах, актлах, шилжүүлэх, орон нутгийн өмчит компаниудын менежментийг сайжруулах, орон нутгийн өмчийн эрхзүйн орчинг боловсронгуй болгох асуудлыг аймгийн ИТХ-ын хуралдаанд танилцуулж, 15 тогтоол шийдвэр гарч, биелэлтийг хангулан ажиллалаа.

1.ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ, ТООЛЛОГО, МЭДЭЭЛЭЛ, ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ

1.1. Орон нутгийн өмчид эд хөрөнгийг бүртгүүлэх:

2021 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж ашиглалтад орсон барилга байгууламжуудыг ТӨБЗГ-ын 2022 оны 186, 482, 483 дугаар тогтоолоор орон нутгийн өмчид хөрөнгө бүртгэх зөвшөөрөл ирүүлсний дагуу орон нутгийн өмчит байгууллагуудад эзэмшүүлж, бүртгэх асуудлыг аймгийн Засаг даргын зөвлөл болон ИТХ-ын зөвлөл, ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанд танилцуулж, 07 дугаар тогтоолоор баталлаа. Тус тогтоолоор 6 нэрийн 5,095,516,196.00 төгрөгийн төсөвт өртөгтэй барилга байгууламжийг холбогдох байгууллагуудад бүртгүүлэх ажлыг зохион байгуулж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт биелэлтийг тайлагналаа. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 392 дугаар тогтоолоор аймгийн Цагдаагийн газарт 54,0 сая төгрөгийн өртөгтэй Уаз фургон машин бүртгэх шийдвэр ирснийг тухайн байгууллагад бүртгүүлсэн.

Өмчийн мэргэжилтнүүд улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр бий болсон хөдлөх хөрөнгийг хүлээн авах 52 удаагийн ажлын хэсэгт ажиллаж, тус хөрөнгүүдийг бүртгэх тухай Орон нутгийн өмчийн газрын даргын 68 тушаалаар нийт 4,6 тэрбум төгрөгийн өртөгтэй хөрөнгийг бүртгэх шийдвэр гаргаж, холбогдох байгууллагын данс бүртгэлд тусгуулсан байна. Мөн өмчийн мэргэжилтнүүд барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авах 6 удаагийн улсын комисст ажиллаж, үл хөдлөх хөрөнгийг орон нутгийн өмчид бүртгүүлэх тухай хүсэлтийг холбогдох яамдад нь хүргүүлж ажиллалаа.

Улсын комисс болон төслийн багт ажиллаж хөрөнгө хүлээж авч буй зураг:






1.2. Орон нутгийн өмчийн тайлан мэдээг, хянаж нэгтгэх.

Орон нутгийн өмчит 220 хуулийн этгээдийн 2021 оны өмчийн 14 төрлийн статистик тайлан мэдээг 2022 оны 1 дүгээр улиралд хүлээн авч, хянаж нэгтгэн 2022 оны 04 дүгээр сарын 03-09-ний өдрүүдэд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүлээлгэн өгч, улсын мэдээнд нэгтгүүллээ. Нийт балансын өртөг 385,9 тэрбум төгрөгийн хөрөнгө орон нутгийн өмчид бүртгэлтэй бөгөөд ашиглалт, хадгалалт хамгаалалтад хяналт тавин ажиллаж байна.

1.3. Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллого:

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 9 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу орон нутгийн өмчит 305 нэгжийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогыг зохион байгуулав.

Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллого зохион байгуулах ажлын хүрээнд тооллого явуулах журам, мэдээ тайлан гаргах, программд оруулах сургалтыг 2022 оны 04 дүгээр 18-ны өдөр Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын холбогдох албан тушаалтуудтай хамтран зохион байгуулж, сургалтыг аймгийн Засаг даргын орлогч М.Хуягбаатар нээж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлстийн дарга Д.Нарангэрэл удирдан явууллаа. ТӨБЗГ-ын мэргэжилтэн Б.Сүнжидмаа, Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн Н.Шинэбаяр, Ц.Бэхбаяр, Ч.Лхагвамядаг нар тооллогын цахим программын сургалтыг зохион байгууллаа. Сургалтанд 265 байгууллагын 395 албан хаагч оролцов.



Аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн А/144 дүгээр захирамжаар аймгийн тооллогын комиссыг томилж, тооллогын комисс дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Аймгийн тооллогын комисс 3 удаа хуралдаж, анхны хурлаараа тооллого зохион байгуулах ажлын төлөвлөгөө, сум, байгууллагад хяналтаар ажиллах удирдамж, хуваарийг баталж, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдэд хүргүүлж, тооллогын ажлыг удирдлага, арга зүйгээр хангаж ажиллалаа. Мөн төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг тооллогын явцад гарч байгаа хүндрэл бэрхшээлийн судалгааг гаргаж, үүний дагуу төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлага, нягтлан бодогч, улсын бүртгэгч, газрын даамлуудыг оролцуулсан цахим уулзалтыг 2022 оны 05 дугаар сарын 19-ний өдөр

зохион байгууллаа. Цахим хурлыг аймгийн Засаг даргын орлогч, тооллогын комиссын дарга М.Хуягбаатар нээж, комиссын гишүүн З.Нямбаяр "Газар зүйн мэдээллийн системд нэвтрэх заавар", комиссын гишүүн Б.Мөнгөнзүл, улсын бүртгэгч н.Азжаргал нар "Төрийн байгууллагын мэдээлэл шинэчлэхэд бүрдүүлэх материал", комиссын гишүүн Θ.Баттулга "Тээврийн хэрэгслийн бүртгэлд хасалт хийлгэх, татвар, торгууль, эзэмшигчийн мэдээлэл шинэчлэх" талаар, комиссын гишүүн Х.Баасансүрэн "Соёлын биет болон үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн




талаар" мэдээлэл өгч, зарим асуултад хариулт өглөө. Цахим хуралд төрийн болон орон нутгийн өмчийн 102 байгууллагын 140 гаруй албан хаагчид оролцлоо.



Улсын үзлэг тооллогыг зохион байгуулвал зохих 305 нэгж, үүнээс хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэлтэй 219 хуулийн этгээд тооллогын комисс томилж, тооллогын ажлыг зохион байгуулж, программын эрхтэй 219 хуулийн этгээд тооллогын дүн мэдээг программ хангамжид 100% орууллаа.

Орон нутгийн өмчийн хэлбэр



- Төсөвт байгууллага, албан газар
- Төсөл сан
- Төсөвт үйлдвэрийн газар
- ОНӨААТҮГ
- ОНӨ болон Өмчийн оролцоотой ХК, ХХК

Аймгийн тооллогын комиссын дарга, Засаг даргын орлогч М.Хуягбаатарын баталсан удирдамжийн дагуу тооллогын комиссын гишүүд 2022 оны 05 дугаар сарын 23-ны өдрөөс 2022 оны 06 дугаар сарын 15-ны хооронд 23 сум, 1 тосгоны тооллогод хамрагдах 220 байгууллагаас 22 сум, 1 тосгоны 170 байгууллагад хяналтын тооллогыг хийж, зөвлөн тусалж, хугацаатай үүрэг даалгавар өгч ажиллав.







Орон нутгийн өмчит 219 хуулийн этгээд, 86 сан, төсөл, нийт 305 нэгжийг эд хөрөнгийн тооллогод хамруулж, тооллогын цахим программд хөрөнгийн мэдээлэл болон тооллогын үр дүнг бүрэн орууллаа.

Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогод 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар тасалбар болгосон **385,981,951,261.65** (Гурван зуун наян таван тэрбум есөн зуун наян нэгэн сая есөн зуун тавин нэгэн мянга хоёр зуун жаран нэгэн төгрөг, жаран таван мөнгө) төгрөгийн нийт хөрөнгө тоологдсон бөгөөд тооллогын дүн, тайланг 2022 оны 10 дугаар сарын 03-10-ны өдрүүдэд Улаанбаатар хотод Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүлээлгэн өгч, улсын мэдээнд нэгтгүүллээ.

Мөн аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаар тооллогын тайланг танилцуулж, орон нутгийн өмчийн тооллогын дүнг, 03 дугаар тогтоолоор баталгаажууллаа.

Хөвсгөл аймгийн өмч хөрөнгө 2016 оны эд хөрөнгийн улсын үзлэг тооллоготой харьцуулахад 2,2 дахин ёссөн байна.

1.4. Орон нутгийн өмчит байгууллагын дарга, нягтлан бодогчтой үр ммч эзэмшүүлэх гэрээ байгуулж, дүгнэх:

Орон нутгийн өмчит 219 байгууллагаас өмч эзэмшлийн гэрээ байгуулж гэрээний хэрэгжилтийг тайлагнавал зохих 190 байгууллагаас 186 байгууллага 2021 оны өмч эзэмшлийн гэрээний хэрэгжилтийг тайлагнаж 2022 оны өмч эзэмшлийн гэрээг байгуулсан гэрээний дундаж хэрэгжилт 85,1% байна. 4 байгууллага гэрээ дүгнүүлээгүй боловч 2022 оны өмч эзэмшлийн гэрээг байгуулсан. Гэрээний биелэлт өмнөх оноос 4,8% иар нэмэгдсэн байна.

1.5. Орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалтад тавих хяналтыг сайжруулах:

Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эзэмшилд байгаа хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, хяналтыг сайжруулах зорилгоор орон нутгийн өмчит хуулийн этгээдийн Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн журмыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас баталсан нийтлэг журамд нийцүүлэн боловсруулж, аймгийн Засаг даргын зөвлөл, ИТХ-ын зөвлөлөөр танилцуулан ИТХ-ын хуралдаанд хэлэлцүүлэхээр дэмжсэн тул 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 10 дугаар тогтоолоор журмыг батлав.

2. ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙГ ХУУЛЬ ЖУРМЫН ХҮРЭЭНД ГҮЙЦЭТГЭХ, ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ХАНГАЖ АЖИЛЛАХ ХҮРЭЭНД:

2.1. Үндсэн хөрөнгө худалдах, актлах, шилжүүлэх ажил.

Орон нутгийн өмчит 3 байгууллагаас 1 дүгээр улиралд үндсэн хөрөнгө актлах, шилжүүлэх санал ирүүлснийг аймгийн ИТХ-ын 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, 2 газар, 3 барилга, 14 нэр төрлийн бусад хөрөнгийг актлах, шилжүүлэх шийдвэрийг 15 дугаар тогтоолоор шийдвэрлүүлж, холбогдох байгууллагад хүргүүлж, биелэлтийг хангуулан ажиллалаа.

Энэ онд төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогыг зохион байгуулахтай холбоотойгоор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 1.6-д “Улсын үзлэг, тооллогын явцад хөрөнгийг шууд данснаас хасах, актлах, устгах, шилжүүлэх, худалдахыг хориглоно гэсэн заалтын дагуу тооллогын ажил дуусч, дүнг баталгаажуулах хүртэлх хугацаанд хөрөнгийн хөдөлгөөнтэй холбоотой шийдвэр гаргаагүй болно.

Тооллогын дүнг баталгаажуулсны дараа тооллогын үр дүнгээр худалдах, актлах, шилжүүлэх санал ирүүлсэн 3 байгууллагын 16 газар эзэмших эрх, 4 байгууллагын 17 барилга байгууламж, 10 байгууллагын 32 тээврийн хэрэгсэл, 12 байгууллагын 258 бусад хөрөнгө, дахин үнэлж худалдах 14 хөрөнгийг худалдах, актлах, шилжүүлэх, Элэгдлээрээ анхны өргтөө нөхсөн боловч цаашид ашиглах шаардлагатай 15 байгууллагын 224 нэр төрлийн хөрөнгийг 264,4 сая төгрөгөөр үнэлж, үнэлгээг шинэчлэн тогтоох ашиглах хугацааг сунгах шийдвэр гаргуулахаар аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж дэмжсэн тул аймгийн ИТХ-ын зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, оны эцэст хурлын даргын захирамжаар шийдвэрлэхээр болсон.

2.2. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн илүүдэлтэй ашиглалтгүй хөрөнгийн дуудлагын худалдаа, орлогын гүйцэтгэл.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 109, 118 дугаар тогтоолоор орон нутгийн өмчит хуулийн этгээдийн илүүдэлтэй, ашиглалтгүй хөрөнгийг худалдах шийдвэр гарсан бөгөөд дуудлагын худалдааны зар мэдээг байгууллагын веб сайт болон сонинд нийтэлж, хууль журмын хүрээнд дуудлагын худалдааг 2022 оны 1, 2 дугаар сард зохион байгуулж, 36 хөрөнгөөс 18 хөрөнгө дуудлагаар зарагдаж, 73,5 сая төгрөг, “Хөвсгөлийн эмийн эргэлтийн сан” ОНӨХК-ийг хувьчлах татан буулгах

үндсэн чиглэлийг аймгийн ИТХ-ын 2022 оны 07 дугаар тогтоолоор батлуулж нээлттэй дуудлага худалдааг сум бүрт зохион байгуулж аймгийн орон нутгийн



орлогод 1204,1 сая төгрөгийн орлого, нийт 1,279.8 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн.

Хөрөнгө худалсаны орлогын төлөвлөгөөг 2022 оны төсөв батлах тогтоолоор аймгийн төсөвт 770,0 сая төгрөг, төсвийн тодотголын тогтоолоор 500,0 сая төгрөг, нийт 1,217.0 сая төгрөгөөр батласны дагуу нийт 1,279.8 сая төгрөгийн орлогыг аймгийн хөрөнгө худалсаны орлого дасанд төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн үзүүлэлттэй байна.

2.3. Орон нутгийн өмчit хуулийн этгээдийн илүүдэлтэй ашиглалтгүй хөрөнгийн түрээс, орлогын гүйцэтгэл

Аймгийн ИТХ-ын хуралдаанаар аймгийн түрээсийн орлогын төлөвлөгөө 25 сая төгрөгөөр батлагдсан бөгөөд орон нутгийн өмчit байгууллагын илүүдэлтэй ашиглалтгүй хөрөнгийн түрээсийн гэрээгээр болон улсын төсвийн хөрөнгө



оруулалтаар бий болсон хөдөө аж ахуйн тоног төхөөрөмж, оёдлын машиныг түрээслээд өмчлөх хэлбэрээр гэрээ байгуулж, нийт 104 түрээсийн гэрээг баталгаажуулан, гэрээний хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж, 29,4 сая төгрөгийг түрээсийн орлогын дансанд төвлөрүүлж, төлөвлөгөөний гүйцэтгэлийг мөн давуулан биелүүлсэн байна.

3.ОРОН НУТГИЙН ӨМЧИТ БОЛОН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ АЖ АХУЙН НЭГЖИЙГ УДИРДЛАГААР ХАНГАЖ АЖИЛЛАХ ХҮРЭЭНД:

Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн зорилтот түвшин, бизнес төлөвлөгөөг батлуулах, удирдлагыг сонгон шалгаруулах, томилох, контрактын гэрээ байгуулах үйл ажиллагааг удирдлага зохицуулалтаар ханганд ажиллаж байна.

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2022 оны Төлөвлөгөө	2022 оны урьдчилсан гүйцэтгэл	өсөлт бууралтын хувь
1	орлого	Төгрөг	22,965,003,334.60	25,290,130,478.10	110.12
2	Зарлага	Төгрөг	26,634,799,579.20	25,036,440,033.10	94.00
3	Үйл ажиллагааны ашиг алдагдал	Төгрөг	(2,286,491,375.70)	2,288,856,629.46	(100.10)
4	хөрөнгийн элэгдэл хороодол	Төгрөг	2,922,262,595.90	2,928,102,039.53	100.20
5	авлага	Төгрөг	794,633,637.79	1,986,783,349.79	250.03
6	Өр төлбөр	Төгрөг	737,566,302.50	1,922,149,812.00	260.61
7	Санхүү тайлангийн ашиг алдагдал	Төгрөг	(3,814,713,246.90)	115,877,001.93	(3.04)

Хөвсгөл аймгийн орон нутгийн өмчит болон оролцоотой аж ахуйн нэгжүүдийн урьдчилсан гүйцэтгэлээр 2022 оны орлогын төлөвлөгөө 22,9 тэрбумыг төлөвлөснөөс 25,2 тэрбум төгрөгийн орлого олж, 110,1 хувийн гүйцэтгэлтэй, зардал 26,6 тэрбумыг төлөвлөж, 25,0 тэрбум төгрөгийн зардал гарч, 94 хувийн гүйцэтгэлтэй, үйл ажиллагаагаар 2,2 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж, санхүүгийн тайлангаар 115,8 сая төгрөгийн ашигтай ажиллах урьдчилсан гүйцэтгэл гарсан.

Богино хугацаат өр авлага нэмэгдэж байгаа нь шатахууны үнийн өсөлт нэмэгдэж нүүрс олборлолт тээвэрлэлтийн зардал нэмэгдэж байгаатай холбогдож байна.

Аймгийн орон нутгийн өмчит дор дурьдсан аж ахуйн нэгжүүд орон нутгийн өмчит 13 компанийн 2022 оны урьдчилсан гүйцэтгэлээр аймагт давхардсан тоогоор 25,6 мянган айл өрх, иргэн, 2680 аж ахуй нэгж, байгууллагад төрийн үйлчилгээ үзүүллээ.

Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой 13 компани 2022 онд улс орон нутгийн төсөвт 1,5 тэрбум төгрөгийг татвар төлбөр хураамжийн орлогоор төвлөрүүлж төлөвлөгөөг 96,8% хувиар биелүүлсэн бол нийгмийн даатгалын

шимтгэлд 1,5 тэрбум төгрөг төвлөрүүлж төлөвлөснөөс 4,4 хувиар давуулан биелүүлсэн амжилттай байна.

Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний биелэлт:

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Нэгтгэл дүн		
			2022 оны төлөвлөгөө	2022 оны урьдчилсан гүйцэтгэл	Гүйцэтгэлийн хувь
1	НДШ-т төвлөрүүлсэн орлого	төгрөг	1,436,159,587.46	1,498,633,441.25	104.35
2	Улс орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн татвар	төгрөг	1,538,005,921.49	1,488,720,919.93	96.80
3	Хөрс хуулалт	тн	1,200,000.00	764,100.00	63.68
4	Олборлосон нүүрс биетээр	тн	115,000.00	115,000.00	100.00
5	Борлуулсан нүүрс биетээр	тн	135,000.00	101,900.00	75.48
6	Худалдан авсан эрчим хүч	мян/квтц	65,932,899.00	73,481,561.40	111.45
7	Борлуулсан эрчим хүч	мян/квтц	54,871,700.00	6,039,100.00	11.01
8	Эрчим хүчний алдагдал	хувь	16.40	17.50	106.71
9	Дулаан үйлдвэрлэл	м3	316,990.54	318,879.71	100.60
10	Үйлдвэрлэсэн цэвэр ус /худгийн ус орно/	тн	200,088.00	224,586.00	112.24
11	Бохир ус татан зайлцуулалт	м3	193,424.86	193,162.50	99.86
12	Халуун усны үйлчилгээ	хүний тоо	45,510.00	40,637.50	89.29
13	Түрээсийн үйлчилгээний тоо		345.00	363.00	105.22
14	Түрээсийн гэрээний тоо//	тоо	287.00	293.00	102.09
15	Заал дүүргэлтийн хувь		1.00	1.00	100.00
16	Хог хаягдал зайлцуулалт	тн	19,669.00	22,355.50	113.66
17	Хог хаягдал түрж булах	м2	9,407.00	9,407.00	100.00
18	Гудамж талбайн гэрэлтүүлэг	тоо	-	246.00	
19	Гэрэлтүүлэгийн асалтын хувь	хувь	58.00	62.40	107.59
20	Гудамж талбайн цэвэрлэгээ \Нэг сард цэвэрлэх авто болон явган зам \Cap тутамд давтамжтай ажил	м2	187,254.00	202,554.00	108.17

21	Ногоон байгууламжийн арчилгaa, цэцэрлэгжүүлэлт	m2	24,188.80	24,188.80	100.00
22	Золбин нохой устгал	тоо	874.00	1,276.00	146.00
23	Нийтийн тээвэр	төг	11,402,000.00	22,225,400.00	194.93
24	Нийт ажиллагсадын тоо	тоо	637.00	637.00	100.00
25	Нийт үйлчлүүлэгч байгууллагын тоо	тоо	2,647.00	2,680.00	101.25
26	Нийт хэрэглэгч иргэд өрхийн тоо жилээр	тоо	25,592.00	25,706.00	100.45

Компаниудын 2022 оны онцлох ажил үйлчилгээг дурдвал:

1.“Могойн гол” ХК 115,0 мян тн нүүрс олборлож, 110,0 мян тн нүүрс борлуулж, орон нутгийн төсөвт ногдол ашгийн төлбөр 252,0 сая төгрөг төвлөрүүлсэн.



2.“Хөвсгөл Ус Суваг” ХХК 196,3 мян м3 ус үйлдвэрлэж, 189,8 мян м3 бохир ус зайлуулж, 263 байгууллага, аж ахуйн нэгж, 2052 айл өрхөд үйлчилгээг үзүүлсэн, дулаан эрчим хүчээр хангах үйлчилгээг 65 айл өрх, 5 төсөвт байгууллага, 11 аж



ахуйн нэгжид, халуун усны үйлчилгээг давхардсан тоогоор 21,0 мян иргэнд үзүүлсэн.

3. “Хөвсгөл Эрчим хүч” ХХК- 73483,5 мян/кВТ/цаг цахилгаан эрчим хүчийг худалдан авч, 60391.0 мян/кВТ/цаг эрчим хүчийг аймгийн төвийн 14 баг, хөдөөгийн 17 сумын нийт 1710 байгууллага, 19670 айл өрх хэрэглэгчдэд борлуулан цахилгааны эрчим хүчээр хангасан. Эрчим хучний алдагдал 17,5% буюу төлөвлөснөөс 1 хувиар



нэмэгдсэн нь Засгийн газраас цахилгааны тарифийн хөнгөлөлттэй холбоотой алдагдлыг нэмэгдүүлсэн байна.

4. Сумдад дулааны үйл ажиллагаа явуулдаг 8 компани нь 318 мян м3 дулаан үйлдвэрлэж, 416 байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхийг дулаан эрчим хүчээр хангах, үйлчилгээг үзүүлж ажиллав. Мөн 5 сумын гудамж талбайн гэрэлтуүлгийн арчлалтын ажлыг хариуцан ажиллан асалтын хувийг 65% хүргэн ажиллав

5. “Шинэ мөрөн худалдааны төв”ОНӨХК худалдаа үйлчилгээний чиглэлээр 263 иргэнд лангуу, павилон, цайны газар, талбай түрээслүүлсэн. Мөн 50.100-ийн огтолцол энергийн төв, аялал жуулчлалын цогцолбороор 5000 иргэн үйлчлүүлсэн байна. Мөн Соёмбо цогцолборын ашилалтыг хариуцан ажиллаж 10 иргэн байгууллагатай түрээсийн гэрээ байгуулан ажиллав.


6. “Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв” ХК нь 12282 айл өрх, байгуулагын 189,8 хог хаягдлыг ачиж зайлцуулж 9400,0 м2 талбайн хог хаягдлыг түрж булах үйлчилгээг үзүүлсэн байна . Мөн Мөрөн сүмтай гэрээ байгуулан 202,5 мян м2 зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээ 24,2 мян м2 ногоон байгууламжийн арчилгааг хийж ажиллав.

7. Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг үр ашигтай зохион байгуулах зорилгоор “Хөдөөгийн Шийдэл”ХХК-ийг байгуулж аймгийн ИТХ-аар дүрмийг батлуулж 2022 онд 3,8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг хуваарилан олгож, иргэн байгууллагад өмчлөх нөхцөлтэй урт хугацаагаар эргэн төлөгдөх түрээсийн гэрээгээр 63 иргэн байгууллагатай гэрээлэн ажиллаж байна. Мөн тус компани 247 ширхэг “Сэлэнгэ” үүлдэрийн үнээ, бухыг төлөөр нь эргэн төлөгдөх нөхцлөөр гэрээ байгуулан олгож түрээсийн орлогоор төлөгдөх эхний бярууг хүлээн авахад бэлэн болсон. Мөн 150 бүл зөгийг 4 сумын 8 иргэнд зөгийн бал, зөгийн бүл салгах нөхцлөөр олгож 2022 онд 10 бүл зөгий салгаж дараагийн иргэд түрээслэх нөхцөл бүрдсэн байна.



Орон нутгийн өмчийн ногдол ашгийн төлөвлөгөө 267,0 сая төгрөг батлагдсанаас гүйцэтгэл 258,0 сая төгрөгийг төвлөрүүлж, “Могойн гол” хувьцаат компанийн ногдол ашгийн төлбөрт 252,0 сая төгрөгийг аймгийн Орон нутгийн орлогод төвлөрүүлж, “Шинэ-Идэр дулаан Эрдэнэт” ХХК, “Тосон Илч” ХХК, “Их-Уул Дулаан” ХХК-иуд нийт 9 сая төгрөгийн ногдол ашгийн орлого сумын орлогодоо төвлөрүүлэхээр ажиллаж байна.

Орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн ногдол ашгийн гүйцэтгэл



“Хөвсгелийн эмийн эргэлтийн сан” ОНӨХК-ийг хувьчлах татан буулгах үндсэн чиглэлийг аймгийн ИТХ-ын 2022 оны 07 дугаар тогтоолоор батлуулж нээлттэй

дуудлага худалдааг сум бүрт зохион байгуулж аймгийн орон нутгийн орлогод 1204,1 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн.

Хөвсгөлийн эмийн эргэлтийн сан ОНӨХК-ийн өрийг барагдуулах тогтоолыг аймгийн ИТХ-ын 2021 оны 05 дугаар тогтоолоор 686 сая төгрөгийг батлуулж өр авлагыг барагдуулж компанийг татан буулгаж дуусгалтын балансыг гаргуулж улсын бүртгэлээс хасуулах үйл ажиллагааг зохион байгууллаа.

4.ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТУХАЙ.

Монгол Улсын Засгийн газрын “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулах тухай” 2020-01-09-ны өдрийн 9 дүгээр тогтоол: Тус тогтоолын дагуу аймгийн Засаг даргын 2022 оны А/144 дүгээр захирамжаар улсын үзлэг, тооллого зохион байгуулах аймгийн комиссыг томилж, байгууллага бүр тооллого зохион байгуулах ажлын хэсгийг тус тус томилж, улсын үзлэг тооллогын ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу 305 нэгж байгууллагын 385,9 тэрбум төгрөгийн хөрөнгийг тоолж, тооллогын дүн мэдээг цахим программаар нэгтгэж, улсын дунд хамрууллаа. Мөн тооллогын дүн мэдээг аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, 03 дугаар тогтоолоор дүнг баталгаажуулав.

“Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 2022-05-25-ны өдрийн 204 дүгээр тогтоол:

Орон нутгийн өмчит 112 хуулийн этгээдийн эзэмшилд 2021 оны жилийн эцсийн байдлаар 672 ширхэг тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаа бөгөөд үүнээс суудлын авто машины тоо 208 ширхэг, үүнээс хэмнэлтийн тухай хуулийн дагуу татан төвлөрүүлэх шаардлагатай 43 суудлын авто машины судалгааг гаргаж, аймгийн Засаг даргад танилцуулж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлсэн.

Татан төвлөрүүлэхээр судалгаа гаргасан 43 тээврийн хэрэгслээс хэрэгцээт байгууллагад шилжүүлж, ашиглах боломжгүй 6 авто машиныг худалдахаар аймгийн Засаг даргын зөвлөл болон ИТХ-ын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, хурлын даргын захирамжаар худалдахаар шийдвэрлэхээр болсон. Бусад авто машины хувьд ТӨБЗГ-аас авто машин ашиглалтын нийтлэг журам батлагдсаны дараа хэрэгцээт байгууллагад шилжүүлэн үйлчилгээнд ашиглах болон худалдах асуудлыг шийдвэрлэхээр хүлээгдэж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр 24 дүгээр тэмдэглэл 2021-04-14, Дугаар: 2021_24

Тус тэмдэглэлээр Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын еренхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд төрийн өмчийн еренхий боловсролын сургууль, цэцэрлэгийн эзэмшил газрыг бусдад шилжүүлэхгүй байх, бүрмэсэн хориглох арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасан бөгөөд орон нутгийн өмчит сургууль, цэцэрлэгийн газар эзэмших эрхийг бусад байгууллагад шилжүүлэх шийдвэр гаргаагүй болно.

“Алсын хараа 2050”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх хүрээнд:

Орон нутгийн өмчит 13 компани, Орон нутгийн өмчийн оролцоотой 1 компани, Орон нутгийн өмчит аж ахуйн тооцот 9 үйлдвэрийн газрын 2022 онд баримтлан ажиллах зорилtot түвшин, эдийн засгийн түвшнийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 119 дүгээр тогтоолоор батлуулан хэрэгжүүлж ажилласан.

Компаний сайн засаглалыг нэвтрүүлэх ажлын хүрээнд орон нутгийн өмчит 4 компани өмчийн оролцоотой 1 компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Х хуралдаанаар томилуулсан. Нийт аймгийн Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой компаниудын Төлөөлөн удирдах зөвлөлд 78 гишүүн томилогдон ажиллаж байгаагаас 52 нь орон нутгийн өмчийн төлөөлөл, 26 нь хараат бус гишүүн томилогдсон байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Орон нутгийн өмчид бий болж байгаа хөдлөх хөрөнгө оруулалт, Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болж байгаа үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийг аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын тушаалаар бүртгэл хийлгэдэг болж хэвшсэнээр хөрөнгө оруулалтын бүртгэл бүрэн хийгдэж байна. 2022 оны 11 сарын байдлаар ОНӨГ-ын даргын 51 дуаагийн тушаалаар 2,9 тэрбум төгрөгийн хөрөнгийг орон нутгийн өмчийн байгууллагуудад бүртгүүлсэн. Мөн өмч хөрөнгийн ашиглалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор байгууллага бүр эд хариуцагч бүртэй эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ байгуулж ажиллах талаар зөвлөмж өгч, Гэрээний төслийг боловсруулж хүргүүлсэн.

Шинэ сэргэлтийн бодлого: Тусгагдсан арга хэмжээний хүрээнд орон нутгийн өмчит 14 компани, өмчийн оролцоотой 1 компани 1үйлдвэрийн газрын Төлөөлөн удирдах зөвлөл, Удирдах зөвлөлд иргэний нийгмийн байгууллага, иргэний төлөөллийг гуравны нэгзэс доошгүй хувийг оролцуулан ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр:

Хөтөлбөрийн хүрээнд 4 арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлагдсан бөгөөд дараах арга хэмжээнүүдийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна. Орон нутгийн өмчийн мэдээллийг цахим программд оруулсан, улсын үзлэг тооллогыг зохион байгуулж, дүнг нэгтгэж баталгаажуулсан, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга, нягтлан бодогчтой өмч эзэмшлийн гэрээ байгуулж дүгнэж хэвшсэн, орон нутгийн өмчит компанийн үр ашгийг дээшлүүлж, орон нутгийн төсөвт 243,0 сая төгрөгийг төвлөрүүлж ажилласан.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 186, 482, 483 дугаар тогтоол:

Тус тогтоолоор улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ашиглалтад орсон барилга байгууламжийг орон нутгийн өмчид бүртгэх зөвшөөрөл ирүүлсний дагуу аймгийн ИТХ-ын хурлын 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн ээлжит бус XVII хуралдаанаар 7 дугаар тогтоолоор бүртгэх шийдвэрийг гаргуулж, холбогдох байгууллагуудад хүргүүлж, биелэлтийг хангуулахаар ажиллаж байна.

Аймгийн ИТХ болон Тэргүүлэгчдийн хурлаар хөрөнгийн харилцаатай холбоотой 40 тогтоол гарсан бөгөөд биелэлтийг тухай бүр холбогдох байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажилласан.

Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг тооллогын бэлтгэл ажил хангах хүрээнд аймгийн Засаг даргын 2021-05-06-ны өдрийн 02 дугаар албан даалгаврыг орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдэд хүргүүлж, хэрэгжилтийн тайланг хүлээн авч, биелэлт 75% байв.

2021 онд хөрөнгө оруулалтын чанарын баталгаа чөлөөлөх болон ажлын хэсэг байгуулах, тооллогын комисс томилох тухай зэрэг аймгийн Засаг даргын 92 захирамжийг боловсруулж гаргасан бөгөөд биелэлтийг 100% ханган ажилласан.

Аймгийн Засаг даргаас 2017 оны А/32 дугаар захирамжаар хөрөнгө бүртгэх ажлыг зохион байгуулах эрхийг Орон нутгийн өмчийн газарт шилжүүлсний дагуу улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөдлөх хөрөнгийг бүртгэх газрын даргын 31 тушаалыг гаргаж, хүргүүлэн байгууллагуудаас бүртгэсэн тухай биелэлтийг YX-1 маягаар авч хэвшсэн.

5.БУСАД АЖИЛ:

1. Энэ онд иргэн болон аж ахуйн нэгж, байгууллагаас 150 албан бичиг, 5 өргөдөл ирсэн бөгөөд өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, хариу хүргүүлж, бусад албан тоот, хүсэлтийг холбогдох байгууллагад уламжлах, хөрөнгийн хөдлөлтэй холбоотой шийдвэрийг холбогдох байгууллагаар гаргуулах зэргээр хариуг хүргүүлж ажилласан. Албан бичгийн хариу болон бусад байгууллагад 131 албан бичгийг албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу гаргаж хүргүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын 4 удаагийн хуралдаанд өмчийн асуудлыг хэлэлцүүлж, 20 тогтоол гарч, холбогдох байгууллагад хүргүүлэн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Хөрөнгө бүртгэх тухай болон ажлын хэсэг томилох тухай Орон нутгийн өмчийн газрын даргын 69 тушаалыг хууль, эрх зүйд нийцүүлэх боловсруулж, батлуулж, биелэлтийг ханган ажиллалаа.

Өмчийн мэргэжилтнүүдийн хөтлөх хэргийн нэрийн жагсаалтанд орсон баримтыг архивын холбогдох журам, зааврын дагуу архивлаж, 45 хадгаламжийн нэгжийг үүсгэн архивлав.

2. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн, "Ногоон суварга босгоё" аяны хүрээнд байгууллагаараа 2022 оны 05 дугаар сарын 14-ний өдөр 10 ширхэг монос, 10 ширхэг гүйлс, 50 ширхэг шар хуайс, нийт 70 ширхэг модыг Удирдлагын ордны зүүн талбайд тарьлаа. Мөн зүүн талын талбайн цэцгийн мандалд 3 төрлийн цэцэг тарив.



3. Бүх нийтийн хог цэвэрлэгээнд 2022 оны 05 сарын 05-ны өдөр болон 2022 оны 9 дүгээр сарын 9-ний өдрүүдэд 2 удаа оролцож, байгууллагын орчны болон Мөрөн сумын 11 дүгээр багийн ард талын талбайг хамт олноороо цэвэрлэлээ.



4.“Хөвсгөл-Хөх сувд” мэсний баярын арга хэмжээнд байгууллагын сурталчилгааны асар барьж, иргэдэд 150 ширхэг брошур тарааж, байгууллагаа сурталчилан, халуун аарц, аньс чацарганаар үйлчилж ажилласан.



Хөвсгөл аймаг байгуулагдсаны 90, 91 жилийн ойн баяраар байгууллагаа сурталчиллах, олон нийтэд таниулах зорилгоор наадмын талбайд сурталчилгааны самбар байршуулж ажилласан.



5.“Дуудлагын худалдааны үр дүн, үр ашиг” гүйцэтгэлийн аудит:

Төрийн Аудитын газраас 2022 оны аудитын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу дуудлагын худалдааны үр дүн, үр ашиг гүйцэтгэлийн аудитыг 2022 оны 9, 10 дугаар

сард хийж гүйцэтгэсэн бөгөөд 2019-2022 оны эхний хагас жилийн дуудлагын худалдааны баримтад аudit хийсэн.

Аудитаар дуудлагын худалдаатай холбоотой зөрчил, дутагдал илрээгүй, дуудлагын худалдааны журмыг шинэчлэн боловсруулах зөвлөмж өгсөн.

Аймгийн Засаг даргын дэргэдэх захирагааны зөвлөлийн 2022 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 09 дүгээр шийдвэрээр эзэмшигч нь аваагүй, холбогдоогүй удаан хугацаагаар тээврийн хэрэгсэл түр saatuuлах байранд хадгалагдаж байсан авто машинуудыг хуучин сэлбэгийн үнэлгээгээр худалдахаар шийдвэрлэсний дагуу үнэлгээ тогтоо болон худалдан борлуулах ажлын хэсэгт өмчийн мэргэжилтнүүд ажиллаж, 25 ширхэг тээврийн хэрэгслийг сэлбэгийн үнээр худалдаж, 4,100,000 төгрөгийг аймгийн хүү, торгуулийн орлогын дансанд төвлөрүүлж ажиллав.

6. Шинэ Мөрөн хорооллын 135 айлын орон сууцтай холбоотой хийгдсэн ажлууд:

Шинэ Мөрөн хорооллын 135 айлын орон сууцны оршин суугчидтай гэрээ байгуулах тухай ИТХ-ын тогтоолын хэрэгжилтийн судлах, гэрээний эргэн төлөлт, үүсээд буй нөхцөл байдлыг судлах, санал дүгнэлт боловсруулах ажлын хэсгийг аймгийн ИТХ-ын 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор байгуулж, ажлын хэсэг нийт 3 удаа хуралдаж, аймгийн ИТХ-ын хуралдаанд орон сууцны талаар 2 удаа асуудал оруулж танилцуулсны үр дүнд 2022 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 07 дугаар тогтоолоор “Орон сууцны талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоол батлагдсан.

Орон сууцны гэрээтэй холбоотой 5 удаагийн хүсэлтийг Сангийн сайд, УИХ-ын гишүүд, Хөгжлийн банкинд хүргүүлж ажиллав.

Оршин суугчдын орон сууцны төлбөр төлөлтийг графикийн дагуу хийхэд анхаарч, 2022 оны 11 дүгээр байдлаар нийт 414,404,047.18 төгрөг түрээсийн орон сууцны эргэлтийн сангийн дансанд төвлөрүүлж ажилласан байна.

6. Цаашид анхаарах асуудлууд:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн программыг санхүүгийн программтай холбогдох байдлаар хийж, ашиглалтад оруулах
2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ашиглалтанд орсон ашиглагч /сургууль, цэцэрлэг, Соёлын төв, ЭМТ, ЗДТГ/ нь тодорхой үл хедлөх хөрөнгийг улсын комисс хүлээж авсан тохиолдолд ТӨБЗГ-аас зөвшөөрөл авахгүйгээр орон нутаг бүртгэдэг болох. 2020 онд улсын төсвийн хөрөнгөөр баригдаж ашиглалтад орсон эрүүл мэндийн салбарын барилгыг бүртгэх зөвшөөрөл одоог хүртэл ирээгүй байна.
3. Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 0 өртөгтэй хөдлөх хөрөнгийн үнэлгээ хийх аргачлал, эрх зүйн орчинг боловсронгуй болгох
4. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж /Арьс боловсруулах, сүү боловсруулах, ноос, эсгий хийх тоног төхөөрөмжүүд, сайн үүлдрийн мал/-ийг иргэн, хуулийн этгээдэд түрээслээд өмчлөх харилцааг тодорхой болгох
5. Төсөвт байгууллагын газар эзэмших эрхийн үнэлгээгээр үнэлэгдэж, Засгийн газрын сан нэмэгдүүлсэн газрыг данснаас хасах болон шилжүүлэхэд Засгийн газрын санг бууруулах эсэхийг шийдвэрлэх

6. Орон нутгийн өмч хариуцсан нэгж, байгууллагын статус, харьялал, чиг үүргийг тодорхой болгох.

ТАЙЛАН БИЧСЭН:

МЭРГЭЖИЛТЭН  Ц.БЭХБАЯР
МЭРГЭЖИЛТЭН  ЧЛХАГВАМЯДАГ

ТАНИЛЦСАН:

ДАРГА  Б.ДОЛЖИНСОРОГДОГ

6715123456 4131053

**ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ӨМЧИЙН
ХАРИЛЦААНЫ ЧИГЛЭЛЭЭР ГАРГАСАН ОРОН НУТГИЙН
ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛЫН ЖАГСААЛТ**

№	Тушаалын товч утга	Огноо	Дугаар
1	Дуудлагын худалдаа зохион байгуулах ажлын хэсэг томилох тухай	2022-02-07	A/09
2	Хөрөнгө бүртгэх тухай	2022-02-15	A/20
3	Хөрөнгө бүртгэх тухай	2022-03-11	A/25
4	Хөрөнгө бүртгэх тухай	2022-03-17	A/26
5	Хөрөнгө бүртгэх тухай	2022-04-12	A/32
6	Хөрөнгө бүртгэх тухай	2022-04-14	A/33
7	Хөрөнгө бүртгэх тухай	2022-04-25	A/37
8	Хөрөнгө бүртгэх тухай	2022-05-09	A/38
9	Хөрөнгө бүртгэх тухай	2022-05-16	A/39
10	Хөрөнгө бүртгэх тухай	2022-05-17	A/40
11	Хөрөнгө бүртгэх тухай	2022-05-23	A/41
12	Хөрөнгө бүртгэх тухай	2022-05-23	A/42
13	Хөрөнгө бүртгэх тухай	2022-05-23	A/43
14	Хөрөнгө бүртгэх тухай	2022-05-23	A/44
15	Хөрөнгө бүртгэх тухай	2022-06-03	A/45
16	Хөрөнгө бүртгэх тухай	2022-06-03	A/46
17	Хөрөнгө бүртгэх тухай	2022-06-03	A/47
18	Хөрөнгө бүртгэх тухай	2022-06-03	A/48
19	Хөрөнгө бүртгэх тухай	2022-06-06	A/49
20	Хөрөнгө бүртгэх тухай	2022-06-17	A/51
21	Хөрөнгө бүртгэх тухай	2022-06-20	A/52
22	Хөрөнгө бүртгэх тухай	2022-06-22	A/53
23	Хөрөнгө бүртгэх тухай	2022-06-22	A/54
24	Хөрөнгө бүртгэх тухай	2022-06-29	A/55
25	Хөрөнгө бүртгэх тухай	2022-07-04	A/56
26	Хөрөнгө бүртгэх тухай	2022-07-06	A/57
27	Хөрөнгө бүртгэх тухай	2022-07-08	A/58
28	Хөрөнгө бүртгэх тухай	2022-07-22	A/59
29	Хөрөнгө бүртгэх тухай	2022-07-27	A/61
30	Хөрөнгө бүртгэх тухай	2022-07-28	A/62
31	Хөрөнгө бүртгэх тухай	2022-07-28	A/63
32	Хөрөнгө бүртгэх тухай	2022-09-01	A/65
33	Хөрөнгө бүртгэх тухай	2022-09-01	A/66
34	Хөрөнгө бүртгэх тухай	2022-09-02	A/67
35	Хөрөнгө бүртгэх тухай	2022-09-06	A/68
36	Хөрөнгө бүртгэх тухай	2022-09-06	A/69
37	Хөрөнгө бүртгэх тухай	2022-09-07	A/70
38	Хөрөнгө бүртгэх тухай	2022-09-15	A/71
39	Хөрөнгө бүртгэх тухай	2022-09-16	A/72
40	Хөрөнгө бүртгэх тухай	2022-09-19	A/74
41	Хөрөнгө бүртгэх тухай	2022-09-19	A/75
42	Хөрөнгө бүртгэх тухай	2022-09-19	A/76
43	Хөрөнгө бүртгэх тухай	2022-09-22	A/77
44	Хөрөнгө бүртгэх тухай	2022-09-29	A/78

45	Хөрөнгө бүртгэх тухай	2022-10-17	A/79
46	Хөрөнгө бүртгэх тухай	2022-10-19	A/80
47	Хөрөнгө бүртгэх тухай	2022-10-21	A/81
48	Хөрөнгө бүртгэх тухай	2022-10-25	A/83
49	Хөрөнгө бүртгэх тухай	2022-11-03	A/84
50	Хөрөнгө бүртгэх тухай	2022-11-08	A/85
51	Хөрөнгө бүртгэх тухай	2022-11-08	A/86
52	Хөрөнгө бүртгэх тухай	2022-11-17	A/89
53	Хөрөнгө бүртгэх тухай	2022-11-23	A/90
54	Хөрөнгө бүртгэх тухай	2022-11-23	A/91
55	Хөрөнгө бүртгэх тухай	2022-12-01	A/92
56	Хөрөнгө бүртгэх тухай	2022-12-01	A/93
57	Хөрөнгө бүртгэх тухай	2022-12-01	A/94
58	Хөрөнгө бүртгэх тухай	2022-12-06	A/95
59	Хөрөнгө бүртгэх тухай	2022-12-08	A/96
60	Хөрөнгө бүртгэх тухай	2022-12-09	A/97
61	Хөрөнгө бүртгэх тухай	2022-12-16	A/98
62	Хөрөнгө бүртгэх тухай	2022-12-19	A/99
63	Хөрөнгө бүртгэх тухай	2022-12-20	A/101
64	Хөрөнгө бүртгэх тухай	2022-12-20	A/102
65	Хөрөнгө бүртгэх тухай	2022-12-21	A/105
66	Хөрөнгө бүртгэх тухай	2022-12-22	A/106
67	Хөрөнгө бүртгэх тухай	2022-12-22	A/107
68	Хөрөнгө бүртгэх тухай	2022-12-22	A/108
69	Хөрөнгө бүртгэх тухай	2022-12-22	A/109

**АЙМГИЙН ИТХ-ЫН ХУРАЛДААНААР ӨМЧИЙН ЧИГЛЭЛЭЭР
ГАРСАН ТОГТООЛЫН ЖАГСААЛТ:**

№	Тушаалын товч утга	Огноо	Дугаар
1	Орон нутгийн өмчийг 2020-2022 онд хувьчлах үндсэн чиглэл батлах тухай	2022-01-07	07
2	Хөрөнгө шилжүүлэх тухай	2022-03-11	5
3	"Хөвсгөл Эрчим Хүч" ХХК-ийн ТҮЗ-ийн гишүүд томилох тухай	2022-04-27	6
4	"Шинэ Мөрөн" ОНӨХК-ийн ТҮЗ-ийн гишүүд томилох тухай	2022-04-27	7
5	"Хөвсгөл Ус суваг" ОНӨХК-ийн ТҮЗ-ийн гишүүд томилох тухай	2022-04-27	8
6	"Эрчим Илч Түлш" ОНӨХК-ийн ТҮЗ-ийн гишүүд томилох тухай	2022-04-27	9
7	"Хөдөөгийн шийдэл" ОНӨХХК үүсгэн байгуулах тухай	2022-04-27	10
8	"Шинэ Мөрөн" ОНӨХК-ийн тайлангийн үнэлгээний тухай	2022-04-27	11
9	"Хөвсгөл Ус Суваг" ОНӨХК-ийн тайлангийн үнэлгээний тухай	2022-04-27	12
10	"Хөвсгөл Эрчим Хүч" ОНӨХК-ийн тайлангийн үнэлгээний тухай	2022-04-27	13
11	"Хот тохижилт үйлчилгээний төв" ХХК-ийн ТҮЗ-ийн гишүүд томилох тухай	2022-04-27	17
12	"Хөдөөгийн шийдэл" ОНӨХК-ийн ТҮЗ-ийн гишүүд томилох тухай	2022-04-27	18
13	"Шишгидийн харгуй" ХХК-ийг үүсгэн байгуулах тухай	2022-04-27	20
14	"Шишгидийн харгуй" ХХК-ийн ТҮЗ-ийн гишүүдийг томилох тухай	2022-09-21	21
15	Орон нутгийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогын дунг баталгаажуулах тухай	2022-12-02	03
16	Өмч хамгаалах байнгын зөвлөлийн журам батлах тухай	2012-12-20	10
17	Хөрөнгө бүртгэх тухай	2012-12-20	07
18	Төлөөлөн удирдах зөвлөлийн зардал батлах тухай	2012-12-20	13
19	Газар эзэмших эрх шилжүүлэх тухай	2012-12-20	09
20	Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн зорилтот түвшин батлах тухай	2012-12-20	11



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 05 өдөр

Дугаар A/144

Морин сум

Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого зохион байгуулах аймгийн тооллогын комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.4, Засгийн газрын 2020 оны 9, 2022 оны 278 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 64 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогыг удирдан зохион байгуулах аймгийн тооллогын Комиссын бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

